ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХӨА-2022/265/НА-СТА-ТШЗ**


Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261628 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг
Утас: 99016320 Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн
Захирал, ахлах аудитор: Б.Мядагмаа
Утас: 99389208 Цахим хаяг: ikhermurun.audit@gmail.com
Чанарын хяналтын менежер: Ц.Мөнхтуяа
Утас: 99382220 Цахим хаяг: munkhtuya2220@gmail.com


Цахим хуудас: www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4-10
3. Аудитын тайлан ........ 11
   3.1 Ерөнхий зүйл ........ 11
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
   3.4 Материаллаг байдал ........ 12
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
   3.8 Аудитын гол асуудал ........ 14
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/202
танай ______ -ны № ______ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН ЛАБОРАТОРИ
"ЭРДМИЙН ДАЛАЙ" ЦОГЦОЛБОР
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ О.БАДРАА
ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Ерөнхий боловсролын лаборатори "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

1720090001 9070605

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **217,940,434.80** | **247,147,807.34** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 217,940,434.80 | 247,147,807.34 |
| **351** | **Түүхий эд материал** | 35,778,058.50 | 40,010,941.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 29,129,941.50 | 29,129,941.50 |
| 35130 | Эм боох материал | 6,648,117.00 | 10,881,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 182,162,376.30 | 207,136,865.84 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 240,000.00 | 940,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 75,839,318.76 | 76,313,165.76 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 530,000.00 | 380,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,320,000.00 | 2,320,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 103,233,057.54 | 127,183,700.08 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,434,770,718.03** | **1,611,521,905.66** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,434,770,718.03 | 1,611,521,905.66 |
| **392** | **Биет хөрөнгө** | 932,451,973.03 | 1,109,345,049.70 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,243,027,287.00 | 1,243,027,287.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -638,103,920.24 | -666,715,598.36 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 432,448,386.45 | 323,741,978.45 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -343,860,559.25 | -77,046,027.41 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 205,063,860.48 | 207,615,255.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -125,634,481.66 | -80,470,365.94 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 104,725,784.50 | 91,835,784.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -46,828,185.28 | -40,253,778.92 |
| 39217 | Ном | 101,613,801.03 | 107,610,515.38 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 502,318,745.00 | 502,176,855.96 |
| 39301 | Програм хангамж | 9,210,605.00 | 9,210,605.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -2,791,860.00 | -2,933,749.04 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 495,900,000.00 | 495,900,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,652,711,152.83** | **1,858,669,713.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,652,711,152.83** | **1,858,669,713.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,652,711,152.83 | 1,858,669,713.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,159,968,168.00 | 1,159,968,168.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,159,968,168.00 | 1,159,968,168.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -308,124,855.60 | -100,775,165.43 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -308,124,855.60 | -306,733,725.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 205,958,560.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 800,867,840.43 | 799,476,710.43 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,652,711,152.83** | **1,858,669,713.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,016,032,284.22** | **3,061,677,119.79** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,592,349,084.22** | **284,456,805.34** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 110,018,884.22 | 284,456,805.34 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 110,018,884.22 | 284,456,805.34 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,545,900.00 | 34,206,550.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 75,472,984.22 | 250,250,255.34 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,906,013,400.00** | **2,777,220,314.45** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,482,330,200.00 | 2,315,849,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,653,800.00 | 40,566,514.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 750,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 33,787,114.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,653,800.00 | 6,029,400.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 405,029,400.00 | 420,804,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 405,029,400.00 | 420,804,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,880,145,575.71** | **2,851,456,418.69** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,880,145,575.71** | **2,851,456,418.69** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,764,731,168.71 | 2,775,290,410.69 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,979,397,470.00 | 1,961,049,635.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,679,287,384.00 | 1,052,268,573.00 |
| 210102 | Нэмэгдэл | 180,681,076.00 | 811,658,496.00 |
| 210104 | Урамшуулал | 119,429,010.00 | 97,122,566.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 249,036,826.00 | 256,704,701.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 170,584,326.00 | 181,428,001.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,613,100.00 | 18,819,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,690,500.00 | 15,055,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,922,600.00 | 3,763,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,226,300.00 | 37,638,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 383,266,660.00 | 393,086,643.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,410,121.00 | 6,238,080.00 |
| 210302 | Түлш, халаалт | 360,469,200.00 | 372,032,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,387,339.00 | 14,815,663.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 44,249,680.05 | 18,564,961.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,280,500.00 | 2,459,405.45 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 970,000.00 | 650,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 641,317.00 | 762,883.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 22,591,800.00 | 9,089,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,806,232.00 | 1,127,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,098,750.00 | 4,475,573.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 5,861,081.05 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 2,979,133.00 | 3,994,470.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,979,133.00 | 3,956,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 38,170.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,360,300.00 | 25,771,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,360,300.00 | 25,771,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 99,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 99,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний** | 1,119,690.00 | 11,713,210.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **төлбөр, хураамж** | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 519,690.00 | 10,705,210.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 87,321,409.66 | 104,305,690.24 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,867,829.00 | 23,819,280.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 62,453,580.66 | 80,486,410.24 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 115,414,407.00 | 76,166,008.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,095,000.00 | 68,098,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 46,482,000.00 | 62,551,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,613,000.00 | 5,546,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,907,440.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,907,440.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 62,411,967.00 | 8,067,608.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 62,411,967.00 | 8,067,608.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **135,886,708.51** | **210,220,701.10** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 4,262,140.93 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 4,262,140.93 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -4,262,140.93 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **135,886,708.51** | **205,958,560.17** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.00** | **00.00** | **00.00** | 00.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,159,968,168.00 | 800,867,840.43 | -308,124,855.60 | 1,652,711,152.83 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,159,968,168.00 | 800,867,840.43 | -308,124,855.60 | 1,652,711,152.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,391,130.00 | 1,391,130.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,159,968,168.00 | 800,867,840.43 | -306,733,725.60 | 1,654,102,282.83 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -1,391,130.00 | 00.00 | -1,391,130.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 205,958,560.17 | 205,958,560.17 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,159,968,168.00** | **799,476,710.43** | **-100,775,165.43** | **1,858,669,713.00** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,940,559,300.00** | **2,811,426,864.45** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,516,876,100.00** | **34,206,550.00** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 34,545,900.00 | 34,206,550.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 34,545,900.00 | 34,206,550.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 34,545,900.00 | 34,206,550.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,906,013,400.00** | **2,777,220,314.45** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,482,330,200.00 | 2,315,849,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 18,653,800.00 | 40,566,514.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 750,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 33,787,114.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 18,653,800.00 | 6,029,400.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 00.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 405,029,400.00 | 420,804,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 405,029,400.00 | 420,804,200.00 |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,853,863,427.00** | **2,784,566,164.45** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,853,863,427.00** | **2,784,566,164.45** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,738,449,020.00** | **2,708,400,156.45** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,979,397,470.00 | 1,961,049,635.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,679,287,384.00 | 1,052,268,573.00 |
| 210102 | Нэмэгдэл | 180,681,076.00 | 811,658,496.00 |
| 210104 | Урамшуулал | 119,429,010.00 | 97,122,566.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 249,036,826.00 | 256,704,701.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 170,584,326.00 | 181,428,001.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 19,613,100.00 | 18,819,200.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,690,500.00 | 15,055,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,922,600.00 | 3,763,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 39,226,300.00 | 37,638,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 383,266,660.00 | 393,086,643.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,410,121.00 | 6,238,080.00 |
| 210302 | Түлш, халаалт | 360,469,200.00 | 372,032,900.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,387,339.00 | 14,815,663.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 49,427,849.00 | 28,543,297.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,520,500.00 | 3,159,405.45 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,500,000.00 | 500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 641,317.00 | 762,883.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 22,591,800.00 | 15,339,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,806,232.00 | 1,546,909.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 14,368,000.00 | 7,234,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,246,850.00 | 3,244,870.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,807,600.00 | 577,700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,439,250.00 | 2,667,170.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,610,975.00 | 26,274,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,145,675.00 | 503,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 19,465,300.00 | 25,771,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 00.00 | 99,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 00.00 | 99,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,119,690.00 | 11,713,210.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 519,690.00 | 10,705,210.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 38,342,700.00 | 27,683,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 38,342,700.00 | 27,683,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **115,414,407.00** | **76,166,008.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,095,000.00 | 68,098,400.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 46,482,000.00 | 62,551,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,613,000.00 | 5,546,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,907,440.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,907,440.00 | 00.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 62,411,967.00 | 8,067,608.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 62,411,967.00 | 8,067,608.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **86,695,873.00** | **26,860,700.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **86,695,873.00** | **26,860,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **86,695,873.00** | **26,860,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 86,695,873.00 | 26,860,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 86,695,873.00 | 26,860,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-86,695,873.00** | **-26,860,700.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 2,770,493,800.00 | 2,762,792,742.00 | 7,701,058.00 | 99.7 |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 2,770,493,800.00 | 2,762,792,742.00 | 7,701,058.00 | 99.7 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,701,058,500.00 | 2,694,694,342.00 | 6,364,158.00 | 99.8 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,961,509,400.00 | 1,961,049,635.00 | 459,765.00 | 100.0 |
| 210101 | Үндсэн цалин | 1,014,531,100.00 | 1,052,268,573.00 | -37,737,473.00 | 103.7 |
| 210102 | Нэмэгдэл | 858,978,300.00 | 811,658,496.00 | 47,319,804.00 | 94.5 |
| 210104 | Урамшуулал | 88,000,000.00 | 97,122,566.00 | -9,122,566.00 | 110.4 |
| 2102 | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 260,303,700.00 | 256,704,701.00 | 3,598,999.00 | 98.6 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 185,027,000.00 | 181,428,001.00 | 3,598,999.00 | 98.1 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 18,819,200.00 | 18,819,200.00 | 00.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 15,055,300.00 | 15,055,300.00 | 00.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,763,800.00 | 3,763,800.00 | 00.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 37,638,400.00 | 37,638,400.00 | 00.00 | 100.0 |
| 2103 | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 395,032,900.00 | 393,086,643.00 | 1,946,257.00 | 99.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 7,000,000.00 | 6,238,080.00 | 761,920.00 | 89.1 |
| 210302 | Түлш, халаалт | 372,032,900.00 | 372,032,900.00 | 00.00 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 16,000,000.00 | 14,815,663.00 | 1,184,337.00 | 92.6 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | 22,541,400.00 | 22,510,983.00 | 30,417.00 | 99.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,733,000.00 | 1,733,000.00 | 00.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 500,000.00 | 500,000.00 | 00.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,233,000.00 | 1,232,883.00 | 117.00 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 10,974,200.00 | 10,974,200.00 | 00.00 | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 866,500.00 | 836,200.00 | 30,300.00 | 96.5 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,234,700.00 | 7,234,700.00 | 00.00 | 100.0 |
| 2105 | **Нормативт зардал** | 3,264,000.00 | 3,244,870.00 | 19,130.00 | 99.4 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 577,900.00 | 577,700.00 | 200.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,686,100.00 | 2,667,170.00 | 18,930.00 | 99.3 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 25,771,300.00 | 25,771,300.00 | 00.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 25,771,300.00 | 25,771,300.00 | 00.00 | 100.0 |
| 2107 | **Томилолт, зочны зардал** | 99,800.00 | 99,800.00 | 00.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 99,800.00 | 99,800.00 | 00.00 | 100.0 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,762,800.00 | 4,743,210.00 | 19,590.00 | 99.6 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,754,800.00 | 3,735,210.00 | 19,590.00 | 99.5 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,008,000.00 | 00.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27773200.00 | 27483200.00 | 290,000.00 | 99.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 27,773,200.00 | 27,483,200.00 | 290,000.00 | 99.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 69435300.00 | 68,098,400.00 | 1,336,900.00 | 98.1 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 69,435,300.00 | 68,098,400.00 | 1,336,900.00 | 98.1 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 63,835,300.00 | 62,551,900.00 | 1,283,400.00 | 98.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,600,000.00 | 5,546,500.00 | 53,500.00 | 99.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,770,493,800.00 | 2,762,792,742.00 | 7,701,058.00 | 99.7 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 2,315,849,600.00 | 2,309,728,249.00 | 6,121,351.00 | 99.7 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,315,849,600.00 | 2,309,728,249.00 | 6,121,351.00 | 99.7 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 420,804,200.00 | 418,857,943.00 | 1,946,257.00 | 99.5 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 420,804,200.00 | 418,857,943.00 | 1,946,257.00 | 99.5 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 33,840,000.00 | 34,206,550.00 | -366,550.00 | 101.1 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 33,840,000.00 | 34,206,550.00 | -366,550.00 | 101.1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 127.00 | 124.00 | 03.00 | 97.6 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 00.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 95.00 | 94.00 | 01.00 | 98.9 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 31.00 | 29.00 | 02.00 | 93.5 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **40,566,514.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **40,566,514.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 40,566,514.45 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,946,514.45 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,426,405.45 |
| 210404 | Ном, хэвлэл | 5,809,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 710,709.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,670,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,670,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,950,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,750,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 200,000.00 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 40,566,514.45 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 40,566,514.45 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 750,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 33,787,114.45 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 6,029,400.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Ихэрмөрөн-аудит ХХК-ийн захирал, ахлах аудитор Б.Мядагмаа, аудиторын туслах Ж.Уранчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Ц.Мөнхтуяа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ нар анхан шатанд, дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 08 дугаар албан бичгээр 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага бөгөөд 2021 онд багш, сурагч, эцэг эхийн хамтын ажиллагааг сайжруулж, үр дүнд тулгуурласан хосолсон сургалтын хэлбэрийг хүүхдийн хөгжил, нас бие сэтгэхүйн онцлогт тохируулан явуулах, сургалтын сайн арга зүйг хэрэгжүүлж, хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг дэмжин ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоол
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр "Босго үнэ шинэчлэх тухай" тогтоол
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр "Тушаалын хавсралт шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,880.1 сая төгрөгөөс 2 хувиар буюу 57.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 46.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 205.9 сая төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үндсэн хөрөнгийн дансны үзүүлэлттэй холбоотой байна.

*/Сая төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 00 | 00 | |
| Авлага | 00 | 00 | |
| Урьдчилгаа | 00 | 00 | |
| Бараа материал | 217.9 | 247.1 | 29.2 |
| Үндсэн хөрөнгө | 1,434.8 | 1,611.5 | 176.7 |
| **Нийт хөрөнгө** | 1,652.7 | 1,858.6 | 205.9 |
| Өр төлбөр | 00 | 00 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,652.7 | 1,858.7 | 205.9 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,652.7 | 1,858.7 | 205.9 |

Бараа материалын дансны үлдэгдэл 247.1 сая төгрөг болж 29.2 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн байна. Төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 127.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээж авсан 15.6 сая төгрөгөөр нэмэгдэж үйл ажиллагаанд 114.3 сая төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 1,611.5 сая төгрөг болж 176.7 сая төгрөгөөр буюу 12.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан машин тоног төхөөрөмж дансанд төсвийн хөрөнгөөр 22.2 сая төгрөгөөр ухаалаг дэлгэц, зургийн аппарат, техник хэрэгсэл, 2.8 сая төгрөгөөр мананцраар ариутгагч хаалга, БШУЯ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 46.9 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж нэмэгдсэн байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 111 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж, "0 үлдэгдэлтэй болсон боловч ашиглагдаж байгаа 255 ширхэг 334.4 сая төгрөгийн анхны өртөг бүхий үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг нэмэгдүүлэн, өртгийг шинэчлэн 187.8 сая төгрөгөөр тогтоосон байна.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглалтын шаардлага хангахгүй 29 нэр төрлийн 60 ширхэг 21.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 21 нэр төрлийн 30 ширхэг тавилга, 2 нэр төрлийн 3641 ширхэг 4.3 сая төгрөгийн ном, сурах бичиг, Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор 12.9 сая төгрөгийн ашиглах боломжгүй гадна бие засах газар нийт 40.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж данснаас хассан байна. Хуримтлагдсан элэгдэл дансанд 80.5 сая төгрөгийн өөрчлөлт гарсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,708.0 сая төгрөг болж 205.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 45.6 сая төгрөгөөр буюу 1.5 өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үзүүлэлт нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого данс байна.

Үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг 2,851.4 сая төгрөгөөр толилуулсан нь өмнөх онтой харьцуулахад 28.7 сая төгрөгөөр буурч, нийт үр дүн 70.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

2021 оны төсвийг 1,417.5 сая төгрөгөөр төсөвлөн хүргүүлсэн байх бөгөөд Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 02 дугаар тогтоолоор 2,409.7 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн жилийн явцад Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 08 дүгээр сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор 267.5 сая төгрөгийн тодотгол цалин, урамшууллын зардалд, Мөрөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоолоор 6.9 сая төгрөг хасагдаж төсөв 2,670.3 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/608 дугаар захирамжаар нэг удаа нэмэх тодотголтой зохицуулалт хийж 100.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсөв 2,770.4 сая төгрөг болсон байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг 2,762.8 сая төгрөгөөр тайлагнасан нь батлагдсан төлөвлөгөө 2,770.5 сая төгрөгтэй харьцуулахад 99.7 хувийн гүйцэтгэлтэй гарч, төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн 7.7 сая төгрөг, өөрийн үйл

ажиллагааны сургалтын төлбөрийн орлого 0.4 сая төгрөг нийт 8.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу 2021 оны төсвийн жилд төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, төсөвт зардлыг хэмнэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд үдийн цай, томилолтын зардлаас хэмнэсэн 58.3 сая төгрөгийг цалин урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд зохицуулалт хийсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах 40.6 сая төгрөгийн орлогыг хүлээн авч зарцуулсан байна. Үүнд:

- Боловсролын газраас ариутгалын зардалд 0.8 сая төгрөг
- Боловсролын чанарын шинэчлэл төслөөс “Сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр-5”-ийн зардал 10.6 сая төгрөг
- Боловсролын мэдээллийн технологийн төвөөс Контент боловсруулах лабораторийн тоног төхөөрөмж худалдан авах зардалд 19.0 сая төгрөг
- Боловсролын газраас “Оношлох үнэлгээний шалгалт”-ын бичиг хэргийн зардалд 1.3 сая төгрөг
- Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газраас ариутгалын зардалд 2.0 сая төгрөг
- Боловсролын үнэлгээний төвөөс “Оношлох үнэлгээний шалгалт”-ын бичиг хэргийн зардалд 0.2 сая төгрөг
- Сурагчдын сурах бичиг хэрэглэсэн хэрэглээний төлбөрийн орлого 5.8 сая төгрөг
- Тендерийн орлого 0.07 сая төгрөг
- Мөрөн сумын Засаг даргын Тамгын газраас ариутгалын тоног төхөөрөмжийн зардалд 0.8 сая төгрөг

Дээрх нэмэлт санхүүжилтийн орлогыг холбогдох байгууллага, албан тушаалтны удирдамж шийдвэрийн дагуу зохих зардалд зарцуулах эрхийг нээлгэж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийхдээ Монгол Улсын ерөнхий аудиторын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/111 дүгээр тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудит хийхэд баримтлах ерөнхий бодлого, чиглэлийн дагуу төсвийн хэмнэлтийн бодлого, зарцуулалт, шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилт, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад асуудалд анхаарлаа хандуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний талаар” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргах заалтыг хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 210 дугаар тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургууль нь 2021 онд нийт 4,354.4 сая төгрөгийн 105 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 4,354.4 сая төгрөгийн 105 мэдээллийг ил тод байршуулсан байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагааны тухайд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан тасалбар болгосон ба тайланг батламжилсан өдрийн хооронд тайланд нөлөө үзүүлж болохуйц үйл явдал болоогүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2.9 сая төгрөгийн зөрчлийг аудитын хугацаанд залруулсан.

### 4.1 Залруулсан алдаа

Бараа материалын тодруулгад 2.9 сая төгрөгийн бусад хангамжийн материалыг аж ахуйн материал дансанд бүртгэсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын лаборатори Эрдмийн далай цогцолбор сургууль | 1 | 2.9 | 1 | 2.9 | - | - | - | - | - | - |

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Э.БАТ-ЭРДЭНЭ Огноо: II/26.

АХЛАХ АУДИТОР Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо:

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР Ц.МӨНХТУЯА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР Б. МЯДАГМАА Огноо: